



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/201

Булган сум

Дотоодын Их, дээд сургуульд элсэн суралцаж
байгаа оюутнуудын төлбөрт хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8, Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөр”-ийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 онд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хамрагдан дотоодын Их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа боловч сургалтын төлбөрийн тэтгэлэг олгогдоогүй оюутнуудын тэтгэлгийг нөхөн олгож, нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авч аймаг, улсад тэргүүлсэн Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч Энхбаатарын Удвалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн урамшууллыг олгосугай.

3.Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулалд шаардлагатай 19,962,100 (арван есөн сая есөн зуун жаран хоёр мянга нэг зуу) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

